



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоол 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 252,664,590.00 төгрөг (хоёр зуун тавин хоёр сая зургаан зуун жаран дөрвөн мянга таван зуун ер)-ийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг данснаас хасч, хавсралтад заасны дагуу аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд бүртгэх;


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132000122  
2026/6-r-huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2026 оны 03 дугаар сарын 19 ны/ний өдрийн  
78... дугаар албан бичгийн хавсралт



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨФӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСЧ  
АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр                          | Ашиглалтад орсон огноо | Тоо, хэмжээ | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт балансын үнэ (төгрөг)   | Хурифтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Шилжүүлэн авах аймгууд   |
|-----|--|------------------------|-------------|-------------------------|--|--------------------------------|-------------------------|--|
| 1   | Суурин компьютер Dell Optiplex i5 7080 | 10/1/2020              | 15          | 2,372,900.00            | 35,593,500.00  | 35,593,500.00                  | -                       | Завхан аймаг (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар)           |
| 2   | Суурин компьютер Dell Optiplex i5 7080 | 10/1/2020              | 15          | 2,372,900.00            | 35,593,500.00  | 35,593,500.00                  | -                       | Увс аймаг (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар)              |
| 3   | Суурин компьютер Dell Optiplex i5 7080 | 10/1/2020              | 20          | 2,372,900.00            | 47,458,000.00  | 47,458,000.00                  | -                       | Ховд аймаг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар)       |
| 4   | Суурин компьютер Dell Optiplex i5 7080 | 10/1/2020              | 25          | 2,372,900.00            | 59,322,500.00  | 59,322,500.00                  | -                       | Өвөрхангай аймаг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар) |
| 5   | Зөөврийн компьютер Dell Latitude i5    | 11/27/2020             | 7           | 2,196,370.00            | 15,374,590.00  | 15,374,590.00                  | -                       | Архангай аймаг (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар)         |
| 6   | Суурин компьютер Dell Optiplex 7080    | 10/1/2020              | 25          | 2,372,900.00            | 59,322,500.00  | 59,322,500.00                  | -                       |  |
|     | Нийт дүн                               |                        | 107         |                         | (хоёр зуун тавин хоёр сая зургаан зуун жаран дөрвөн мянга таван зуун ер) | 252,664,590.00                 |                         |  |